

## МОНГОЛ, ХЯТАД ХЭЛНИЙ АДИЛТГАЛ, ЗҮЙРЛЭЛИЙГ ОРЧУУЛГАД АВЧ ҮЗЭХ НЬ

Wurenzaorige<sup>106</sup>, Г.Элдэв-Очир<sup>107</sup>

**Товч утга:** Соёлын гарал үүслийн ялгаа нь хэлний бүтцийн ялгааны эх сурвалж юм. Хэлний ялгаа нь өөр өөр улс үндэстний хоорондох сэтгэхүйн ялгааны илэрхийлэл юм. Хэл гэдэг нь хүний ерөнхий ойлголт, үзэл бодол, утга санаа зэргийг илэрхийлж хоорондоо харилцахад хэрэглэгддэг дохио зангаа, хэлзүй, тэмдэглэгээ, дуудлага, үг зэргийг бүхэлд нь хамруулсан тогтолцоо юм. Өөр өөр улс үндэстний хэлний ялгаануудыг судалснаар тухайн улс орны ард түмний хоорондын харилцаа холбоог нэмэгдүүлж, орчуулгыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн энэхүү ялгаа зөрөө буй болсон шалтгааныг судалснаар эхийг илүү сайн гүнзгий ойлгох боломжтой бөгөөд хамгийн зөв аргаар оновчтой орчуулж хэлний орчуулгын үйлчилгээг илүү сайн чанартай хийх боломж бүрддэг.

**Түлхүүр үг:** Уран дүрслэл, адилтгал, зүйрлэл, орчуулах, нөлөөлөх хүчин зүйлүүд

### Нэг. Сэтгэхүй ба танин мэдэхүйн ялгаа

Хэл яриа ба сэтгэхүй нь хоорондоо нягт уялдаа холбоотой харилцан хамааралтай нэг зүйлийн хоёр тал болно. Сэтгэхүйн арга бол хүмүүс ямар нэгэн ухагдахууныг судлах, анализ хийж дүгнэлт гаргах, шалтгааныг тайлбарлахад ухамсартайгаар, эсвэл, ухамсаргүйгээр ашигладаг арга юм. Аливаа улс үндэстний газарзүйн байрлал, орчин нөхцөл, үндсэн үйлдвэрлэл, амьдралын хэв маяг зэрэг хүчин зүйлүүд нь тухайн үндэстний ерөнхий сэтгэхүйн арга замыг тодорхойлдог. Тухайн улс үндэстний өнгөрүүлсэн түүхэн шат үе, үндэсний соёл, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн төвшин зэрэг нь тухайн үндэстний сэтгэхүйн арга барилд мөн тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлдэг. Тэдний дундаас тухайн улс үндэстний амьдралын зан үйл, амьдралын хэв маяг нь тэдний сэтгэхүйд маш их нөлөө үзүүлдэг. Адил бус соёлын үндэс суурь нь харилцан ондоо амьдралын хэв маяг, сэтгэхүйн арга барил, илэрхийлэх арга зэргийг бий болгодог. Иймээс монгол, хятад хэлээр уран дүрслэл, адилтгал, зүйрлэлийг ашиглах явцад өөр өөр илэрхийлэх арга барилыг ашигладаг. Күнзийн үзэл суртлын нөлөөн дор хятад үндэстэн нь хүн чанар, хүмүүнийг хайрлах, энэрэнгүй, нигүүлсэнгүй байх, хүнлэг байх зэрэг хүн болон олон нийт гэсэн зүйлд илүү их анхаарлаа хандуулдаг бол нүүдэлчдийн амьдралд удаан хугацаагаар амьдарч ирсэн монголчууд нь хүмүүнийг хайрлахаас гадна байгаль дэлхийд мөн анхаарал тавьдаг.

---

<sup>106</sup> МУИС, ШУС, ХУС-ын “Гадаад хэлний орчуулгазүй”-н магистрант

<sup>107</sup> МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим, доктор

Уран дүрслэл зүйрлэлийн эх бүтээхийн урьдчилсан нөхцөл нь зохиогчийн бодит байдал болон бодит объектуудын талаархи ойлголт, танин мэдрэхүй юм. “Мэдрэхүй нь нэг зүйлсийн хувийн шинж чанар ба онцлогийг тусгадаг. Жишээ нь, гэгээтэй бараан өнгө, хөг ая, үнэр, өргөн нарийн, зөөлөн хатуу гэх мэт. Гэвч ухамсрын мэдрэмж нь нэг зүйлийн цогц байдал ба түүний холбоо, харилцааг тусгадаг. Жишээ нь, гал улаан туг, гэрэл гэгээтэй байшин, дуу чимээ, зөөлхөн хөнгөхөн ноосон цамц гэх мэт. Ухамсрын мэдрэмж нь мэдрэхүйн үндсэн дээр буй болдог бөгөөд мэдрэхүйг шууд хольж хутгасан зүйл биш. Ухамсрын мэдрэмжид хүний мэдлэг туршлага чухал үүрэг гүйцэтгэдэг”<sup>108</sup> (Зу Дэши, Хэлзүйн дүрмийн анализ, дүрмийн систем өгүүлэл, 2016) Мэдрэхүй болон ухамсрын мэдрэмжээр дамжуулан хүмүүс өөрсдийн бодол санаа оюун ухаандаа бодитой зүйлийн тухай ойлголт, танилт, туршлагаа хадгалж чаддаг бөгөөд үүгээрээ ертөнцийг таньж чаддаг. Зүйрлэл нь энэхүү урьдчилсан нөхцөл дор ажиллаж эхлэх ба үндсэн зүйл нь бодитой оршиж буй зүйлийн хувьд хүний мэдрэмжийг өдөөж түүний тархинд тод, томруун хэлбэр дүрсээр орж урьд оюун ухаанд нь нэгэнт хадгалагдсан байсан ойлголт, танилт нь оновчтой гэсэн зүйрлэхүүнээ олж тогтоон зүйрлэлийн эхний алхам болдог.

Жишээ нь: 石拱桥的桥洞成弧形,就像虹。(茅以升《中国石拱桥》)

Чулуун нуман гүүрийн гулдан нь солонго шиг муруй хэлбэртэй болно. (Мао Ишөн, “Хятадын чулуун нуман гүүр” зохиол)

Зохиолч гол дээр барьсан чулуун нуман гүүр болон түүний гулдан нь муруй хэлбэртэй байхыг нүдээрээ харж эхний мэдрэхүй үүссэн ба “муруй хэлбэртэй гулдан” гэх бодитой хэлбэр дүрс зохиогчийн тархинд орж түүний тархинд хадгалагдаж байсан ижил төстэй “солонго” гэдэг хэлбэр дүрстэй харьцуулан илтгэж нэг юм үзэгдлийн тухай зүйрлэл ингэж үүсэж байна.

Тухайлбал, монголчууд сүү цагаан идээ хэрэглэдэг тул цагаан өнгөөр сэвгүй ариун сэтгэлийг бэлгэдэж, цагаан өнгийг юм бүхний эхлэл гэж үздэг. Цагаан сар, цагаан толгой, цагаан санаа гэх мэт. Гэвч хятадын соёлд яг эсрэгээр цагаан өнгө нь цусгүй, амьгүйн илэрхийлэл бөгөөд муу муухай, үхэл, өвчин зовлон, гашуудлыг илэрхийлдэг. Жишээ нь: 白事, 白旗, 白忙活, 白痴 гэх мэт. Иймээс цагаан сар, цагаан толгой, цагаан санаа гэсэн үгсийг хятадын зан үйл, хятад хүний хүлээн авах боломжид тулгуурлан шууд 白月, 白字母(头), 白心 гэж орчуулж болохгүй бөгөөд 春节, 字母, 善心 гэж орчуулах нь зүйтэй. Мөн 白事, 白旗, 白忙活, 白痴 гэсэн үгсийг шууд үгчилэн цагаан үйл, цагаан туг, цагаан яаруу, цагаан тэнэг гэж орчуулбал хэн ч ойлгохгүй бөгөөд монгол хүнд ойлгуулахын тулд буяны ажил, бууж өгөх, шал дэмий юм хийх, усан тэнэг гэж орчуулах нь зүйтэй. Монголчуудад есөн хөлт цагаан туг нь төрийн сүр хүч, тусгаар тогтнол, эв нэгдлийн бэлгэдэл болдог бол хятадад цагаан туг нь ялагдал, бууж өгөхийг төлөөлдөг. Монгол үндэстэн болон Хятад үндэстний адил төстэй талуудыг мөн харилцан ондоо арга замаар илэрхийлдэг. Жишээ

<sup>108</sup>朱德熙,语法分析和语法体系,载《中国语文》1982(1)

нь: дотоодын эв нэгдлийг эрхэмлэсэн “家丑不外扬” (гэрийнхээ муу муухайг гадагш нь үл задруулах) гэсэн үгийг шууд утгаар нь биш харин “толгой хагаравч малгай дотроо, олгой хагаравч тогоон дотроо” гэдэг зүйр цэцэн үгээр орлуулж орчуулбал илүү оновчтой байна. Иймд монгол болон хятад үндэстэн нь бодит ертөнцийн оршин тогтнох тухай мөн харилцан адил бус танин мэдэхүйн сэтгэхүйтэй байдаг.

Хоёр үндэстэн угсаатны газарзүйн орчин, амьдралын хэв маягаас шалтгаалан тэдний гоо зүйн төсөөлөл ба онцлог нь мөн харилцан адилгүй байх бөгөөд энэ нь мөн хэлэнд тусгалаа олж байна. Жишээ нь: Монголчууд үзэсгэлэнт сайхан байгалийг онгон байгаль, байгаль ээж гэх мэтээр илэрхийлдэг боловч хятадад ерөнхийдөө “美如画” (зураг шиг сайхан гоо үзэсгэлэнтэй) гэсэн үгээр л илтгэдэг. Өөр өөр үндэстний сэтгэл зүйн онцлог шинж, амьдралын зан заншил нь тэдний танин мэдэхүй, сэтгэлгээнд шууд нөлөөлдөг.

### **Хоёр. Газар зүйн байрлалын ялгаа**

Хүн төрөлхтний оршин амьдарч байгаа газар зүйн байрлал нь түүний соёл үүсэхэд мөн чухал нөлөө үзүүлдэг. Харилцан адилгүй газар зүйн орчин нь мөн өөр өөр соёл иргэншлийг буй болгож өөр өөр соёл иргэншил нь ондоо хэл яриа болон хэл яриатайгаа тохирсон илэрхийлэх арга барилыг буй болгодог. Үүнд газар нутаг, уур амьсгал, байгаль орчин зэрэг нь харилцан адилгүй бүс нутгийн соёлуудын ялгааг үүсгэдэг.

Хятад үндэстний дийлэнх нь чийглэг уур амьсгалтай уул ус, ой мод ихтэй бүс нутагт амьдардаг тул “山穷水尽” (шууд утга нь уул усны эцэс төгсгөлд хүрэх, явах зам гарах гарцгүй мухардалд орох, элдвээр оролдовч, учир нь үл олдох, арга барагдах, туйлдах байдлыг зүйрлэдэг) “山高水远” (шууд утга нь уул өндөр ус хол, бартаа саад ихтэй хол замыг зорилгодоо хүрэхийн тулд туулах, саад бэрхшээлийг зүйрлэдэг) гэх мэт уул ус нь суурьшмал амьдралтай холбоотой уран дүрслэл адилтгал, зүйрлэлийн хэллэг маш олон байдаг ба “胸有成竹” (шууд утга нь цээжин дотроо хүртэл хулс ургуулсан, Хойд Сүн гүрний үеийн хулсны зургийн мастер зураач Вөн Тунгийн үлгэргээс гаралтай. Вөн Тун нь зөвхөн хулсыг сайн зурахын тулд хавар, зун, намар, өвөл, салхитай, бороотой, нартай, үүлтэй эсэхээс үл хамааран хулсан ойд хулс ажигладаг байсан ба хүмүүс түүнийг цээжин дотроо хүртэл хулс ургуулсан гэж магтдаг байсан нь одоо үед юмыг хийхээс өмнө нарийн судлан төлөвлөж чадварлаг, бэлтгэлтэй, итгэлтэй болох байдлыг зүйрлэдэг) “青梅竹马” (шууд утга нь ногоон чавга хулсан морь, Тан гүрний үеийн нэрт яруу найрагч Ли Байгийн

“Хархан багын найз чи минь

Хулсан морь унаж манайд ирдэг байсан

Хамтдаа бид ногоон чавга шидэлцэж

Худаг тойрон тоглодог байсан

Хамтдаа бид Чан Ганли гудамжинд амьдардаг байсан

Хоёр багын сэтгэл хардах сэрдэх юмгүй ариухан цэвэрхэн байсан Арван дөрөвхөн насандаа Амраг чамдаа мордоход инээмсэглэж ч чадалгүй ичимхий байлаа гэдэг шүлгээс гаралтай. Хар багаасаа танилцан мэдэлцэж айл гэр болж амьдрах хосуудыг зүйрлэдэг. Монголын өндгөн сүйтэй төстэй. Гэхдээ эцэг эх нь хэлэлцэн тохирсон ургийн болзоо бус сайн дурын янаг дурлалыг зүйрлэдэг) зэрэг нь хятад үндэстний амьдарч буй газарзүйн орчинтой нягт холбоотой байдаг. Дээр дурдсан хулс мод болон хулс модны нахиа найлзууртай холбоотой адилтгал, зүйрлэлийг монгол оронд түгээмэл ургадаг өөр мод ургамлаар орлуулж орчуулах эсвэл тайлбарлаж орчуулахгүйгээр шууд утгаар нь орчуулбал ойлгоход мөн хэцүү болно. Жишээ нь мөн сайн эр баатар хүнийг зүйрлэдэг “绿林好汉” гэдэг үгийг шууд утгаар нь “ногоон шугуйн сайн эр” гэж орчуулах бус “шилийн сайн эр”, эсвэл, “талын сайн эр” гэж орчуулбал монгол хүн нэн хялбархан ойлгох болно.

Монгол орны газар зүйн байрлал нь хуурай эрс тэс уур амьсгалтай жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага байдаг тул монгол хэлний уран дүрслэл адилтгал, зүйрлэлд байгаль, тал нутаг, цөл, говь, таван хошуу малтай холбоотой зүйлүүд маш их байдаг. Жишээ нь “хээр хонож, хэц дэрлэх” “эр хүний жаргал ээрэм талд” “ямааны мах халуун дээрээ” гэх мэт.

### Гурав. Ёс заншил, зан үйл, түүх соёлын ялгаа

Улс үндэстнүүдийн өөрийн гэсэн соёл уламжлал, өвөрмөц ёс заншил нь тэдний өвөг дээдсээс уламжлан ирсэн үндэстний соёлын сууриас үүдэлтэй. Улс үндэстний соёлын холбогдолтой үг хэллэг нь тухайн үндэстний үндсэн шинж чанар, ёс заншил, зан үйлийн хэв маягийг тод томруун харуулж байдаг.

Монгол, хятад хэлэнд амьтныг зүйрлэгдэхүүн болгож тухайн юм үзэгдлийг зүйрлэсэн байдал нэлээд тохиолддог бөгөөд дараахь жишээгээр харьцуулж үзвэл:

Зүйрлэгдэхүүн амьтан	Зүйрлэх утга	
	Монгол хэлэнд	Хятад хэлэнд
Туулай	Сандруу тэвдүү, аймхай Жишээ: туулайн зүрхтэй, Бушуу туулай борвиндоо баастай	Хурдан Жишээ: 惊猿脱兔 (үргэсэн сармагчин алдагдсан туулай) 静如处女, 动如脱兔 (Жаал охин мэт тайван амгалан Алдагдсан туулай мэт хурдан омоглон)
Үхэр	Амар тайван, зөрүүд, тэнэг Жишээ: сүх далайтал үхэр амар, үхэр шиг тэнэг	Тэнэг, шударга, шаргуу Жишээ: 对牛弹琴 (үхэрт хөгжим дарах,

		юм ойлгохгүй тэнэг гэсэн санааг зүйрлэдэг) 黄牛精神 (шар үхэр мэт зүтгэх)
Гахай	Заваан, тарган, удаан, ховдог идэмхий. Жишээ: Гахай зөөх, гахай шиг амьтан, гахай шиг идэж уух	Залхуу, тэнэг, ёс суртахуунгүй Жишээ: 猪朋狗友(гахай шиг найз, нохой шиг нөхөд) 死猪不怕开水烫 (Үхсэн гахай буцалсан уснаас айхг Ичих нүүргүй ёс суртахуунгүй байдл зүйрлэдэг) 蠢猪笨猪(тэнэг гахай мангар гахай )
Хонь	Номхон, ноомой, жижиг Жишээ: Хонь шиг номхон, Хонин хашаа	Элдэг зөөлөн, хөөрхөн 温顺如羊(хонь мэт элдэг зөөлөн) 可爱如小绵羊(жижиг хонь мэт хөөрхөн)

Урт удаан түүхэн хугацааны туршид улс үндэстэн бүр өөрийн гэсэн өвөрмөц түүх, соёлын үзэл баримтлалуудыг бий болгосон байдаг бөгөөд энэхүү үзэл баримталууд нь тэдний хэлээр дүрслэгдэн илэрдэг. Хятад хэлийг бусад хэлэнд орчуулахад хамгийн хүндрэлтэй нэг зүйл бол хятадын түүхэн хүн, түүхэн үйл явдал, түүхэн үлгэр домогтой холбоотой маш олон хэлц үг, зүйр үг, уран дүрслэл, адилтгал, зүйрлэлүүд байдаг. Түүхэн үлгэрүүд нь тухайн үндэсний түүх, соёлын мөн чанарыг тусгадаг соёлын чухал хэсэг мөн бөгөөд түүх, соёлын онцлог шинжийг хамгийн сайн тусгаж чадах хүчин зүйл юм. Иймд цаана нуугдаж буй түүхэн хүн, түүхэн үйл явдал, түүхэн үлгэрийг нарийн ойлгож судалсны үндсэн дээр орчуулбал илүү хялбар болно. Хятад үндэстний түүх, соёлд “Цао Цао”, “Жу Гөлян”, “Бо Чинтян”, “Күнз” гэх мэт түүхэн хүнтэй холбоотой маш олон үг хэллэг байдаг. Жишээ нь: 完璧归赵 (Шууд утга үнэт хаш эдлэлийг эзэн Жао гүрэнд бүрэн бүтэнээр нь буцааж хүлээлгэн өгөх. Сы Мачяны “Түүхийн тэмдэглэл” гэх зохиолоос гаралтай. Байлдаант гүрний үед болсон түүхэн үлгэр юм. Линь Шяну гэдэг сэргэлэн түшмэл нь хааныхаа үнэтэй хаш эдлэлийг уран арга хэрэглэн Чинь гүрнээс Жао гүрний нийслэлд бүрэн бүтэн буцаан авчирсан үлгэр болно. Харин одоо шилжсэн утгаар эд зүйлсийг тухайн эзэмшигчид нь бүрэн бүтэн буцаан өгөх үйлийг зүйрлэдэг) 四面楚歌 (шууд утга нь дөрвөн зүгээс Чу улсын дуу хангинана. Чу улсын хаан Шян Юй болон Хань улсын Лю Бан нарын тулалдааны үеийн үлгэр бөгөөд Чу улсын цэрэг ялагдаж Хань улсын цэрэгт бүслэгджээ. Лю Бан нь олзлогдсон Чугийн цэрэг болон өөрийн цэрэг доторх Чу улсын дууг мэддэг цэргүүдээрээ Чу нутгийн дууг шөнөжин дуулуулжээ. Бүслэгдсэн Чу улсын цэрэг нь нутгийнхаа дууг сонсон гэр

орноо санаж тулалдах сэтгэлгүй болж хаан Шян Юй нь яагаад дөрвөн зүгээс бүгд Чу улсын дуу хангинаад байна гэж гайхаад Чу улсын ард олон Хань улсад бууж өгсөн юм байх даа хэмээн сэтгэлээр унаж эцэстээ ялагдаж Үжян мөрөнд үйж амиа хорлосон байдаг. Одоо хүмүүс олон талын халдлага, хавчлагад өртөж, хүнд хэцүү нөхцөл байдалд орсон байдлыг зүйрлэдэг), 三顾茅庐 (шууд утга нь овоохой гэрээр нь гурвантаа зочлох. Хань гүрний үед Лю Бан нь Жу Гөлян гэгчийг цэргийн багшаар урьж ажиллуулахаар гурван удаа түүний урц овоохой, гэрээр нь өөрийн биеэр зочилсон үлгэр юм. Одоо чин сэтгэлээсээ олон удаа очиж уулзан эрдэмтэн мэргэдийг урьж ажиллуулахыг зүйрлэдэг) гэх мэт хэлц зүйр үгийг цаана агуулагдаж буй түүхэн хүн, түүхэн үйл явдал, түүхэн үлгэрийг мэдэхгүйгээр шууд орчуулах боломжгүй бөгөөд орчуулахдаа нэг бол орлуулж орчуулах, нэг бол цаад түүхийг тайлбарлан орчуулах шаардлага тулгардаг.

Монгол, хятад хоёр ард түмэн нь хэл уран зохиол, үндэсний соёл, гарал үүсэл, амьдралын орчин, нийгмийн хэв маяг зэргээр маш их ялгаатай байдаг бөгөөд энэ нь хоёр үндэстний хэлээр дамжиж бүрэн тусган илэрхийлэгддэг. Монгол, хятад хэлний уран дүрслэл адилтгал, зүйрлэлийг илэрхийлэх аргыг харьцуулан судалснаар адилтгал, зүйрлэл нь зөвхөн нэг үндэстний хэл шинжлэлийн өвөрмөц үзэгдэл биш бөгөөд харин бүхэл бүтэн үндэстний соёлын гүн гүнзгий утга агуулга, үндэсний онцлогийг агуулж байдаг нь илэрхий болж байна. Хоёр үндэстний уран дүрслэл адилтгал, зүйрлэлийг илэрхийлэх аргын ялгаа буй болгосон хүчин зүйлүүд нь харилцан адилгүй хэлний бүтэц, тогтолцооноос гадна, нийгэм хүмүүнлэгийн байдал, хүрээлэн буй орчин, соёл, түүх болон бусад олон хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэлийн үр дүн юм.

Монгол, хятад хэлний орчуулгын ажлын явцад орчуулагч нь дээр дурдсан хүчин зүйлүүдийн нөлөөнд байнга автдаг. Иймээс орчуулгыг чанарын өндөр төвшинд сайн хийхийн тулд эхлээд хоёр хэлний аль алийг бүрэн сайн ойлгох, дүн шинжилгээ хийх чадвартай байх ёстой бөгөөд мэргэжлийн хэлний хэрэглээний чадавхтай байх хэрэгтэй. Дараа нь холбогдох орчуулгын аргыг маш сайн сурч эзэмшсэн байх ёстой бөгөөд орчуулга хийхдээ эхийн агуулгаас эхлээд хэлзүйн бүтэц, утгазүй зэргийг нарийн судалж хамгийн оновчтой орчуулгын аргаар орчуулж, орчуулгаар дамжуулан эх бүтээлийн утга санаа, амин сүнс, бичвэрийн хэв маяг зэргийг үнэн зөв илэрхийлсэн байх хэрэгтэй.

#### Ном зүй:

1. 朱德熙, 语法分析和语法体系, 《中国语文》, 1982 年
2. 百度百科 <https://baike.baidu.com/item/比喻修辞手法/5187519>
3. 文化与翻译 中国社会科学院出版社 2010 版
4. 易蒲(宗廷虎), 李金苓, 汉语修辞学史纲, 长春, 吉林教育出版社, 1989 版
5. 《当代学术入门:文学理论》, 乔纳森. 卡勒, 沈阳, 辽宁大学出版社, 1998 版, 74 页
6. 陈望道, 修辞学发凡, 上海, 上海教育出版社, 1982 版
7. Г.Элдэв-Очир, Соёлын утгыг орчуулах арга зам, Орчуулга зүй, 2013, №02